



V/2021

Тархаасан: 2021 оны 6 дугаар сарын 13



## Нийт тариалсан талбай өмнөх оны мөн үеэс 6.6 мянган га-гаар буюу 1.7 хувиар буурлаа

Улсын хэмжээнд 2021 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар 368.5 мянган га талбайд тариалалт хийснээс үр тариа 328.8 мянган га-д, техникийн ургамал 16.0 мянган га-д, төмс 11.6 мянган га-д, таримал тэжээлийн ургамал 7.8 мянган га-д, хүнсний ногоо 4.1 мянган га-д, бусад ургамал 0.1 мянган га-д тариалсан байна.

Хүснэгт 1. Тариалсан талбай, ургамлын төрлөөр, жил бүрийн 6 дугаар сарын 1-ний байдлаар

	2018 VI.1	2019 VI.1	2020 VI.1	2021 VI.1	<u>2021 VI.1</u> 2020 VI.1
	мянган га				хувь
Бүгд	382.1	377.0	375.1	368.5	98.3
Үр тариа	313.0	318.1	325.3	328.8	101.1
Бүүдай	300.9	300.9	315.3	317.6	100.7
Төмс	10.2	11.5	13.4	11.6	86.4
Хүнсний ногоо	4.8	4.3	5.4	4.1	76.1
Таримал тэжээл	14.2	12.9	9.5	7.8	82.7
Техникийн ургамал	39.5	30.3	21.0	16.0	76.4
Бусад	0.4	0.0	0.5	0.1	25.7

Нийт тариалсан талбай өмнөх оны мөн үеэс 6.6 (1.7%) мянган га-гаар буурсан байна. Ургамлын төрлөөр тариалсан талбайг авч үзвэл, техникийн ургамал 5.0 (23.6%) мянган га, төмс 1.8 (13.6%) мянган га, таримал тэжээлийн ургамал 1.6 (17.3%) мянган га, хүнсний ногоо 1.3 (23.9%) мянган га, бусад ургамал 0.4 (74.3%) мянган га-гаар тус тус буурч, харин үр тарианы тариалсан талбай 3.6 (1.1%) мянган га-гаар нэмэгдсэн байна.

### Ойлголт, тодорхойлолт:

**Тариалсан талбай** гэж газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг ойлгоно.

### Тооцох аргачлал:

**Тариалсан талбай:** Хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.

**Нийт хураасан ургац:** Тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг таримал ургамлын хэмжээгээр тодорхойлно.

**Га-гийн ургац:** Талбайн нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ юм. Га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамал тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулна.

Эх үүсвэр: ҮСХ, Газар тариалангийн мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 7 дугаар сарын 19



*Эдийн засгийн статистикийн газрын*

*дарга Э.Эрдэнэсан*

*Утас : (976-51)-266414*

*Эдийн засгийн статистикийн газрын*

*Статистикч Х.Энхжавхлан*

*Утас : (976-51)-261565*